



“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК
БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо Цэцээгүн 206 тоот
Утас: (+976) 990965848 (+976) 70001981
И-мэйл: csi_sevjee@yahoo.com

Г “Гермес Центр” ХК-ийн ТУЗ болон
Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг
танаа

2024.01.28 № 23/06.

Танай _____-ны № _____-т

Г **Хараат бус аудиторын тайлан**

Дүгнэлт:

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу “Гермес Центр” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд гэрээний дагуу аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Гермес Центр” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд:

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байна.

Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна

Бусад мэдээлэл:

СИ ЭС АЙ АУДИТ ХХК
Хуудасны дугаар

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой.

Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага:

Санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэж танилцуулах нь байгууллагын гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага юм.

Энэхүү санхүүгийн тайлангуудыг залилан болон алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийллээс ангид буюу үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналтын системийг бий болгох, тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үнэн зөв, бодитой бэлтгэгдсэн эсэхийн хариуцлагыг байгууллагын удирдлага хүлээнэ.

Аудиторын хүлээх хариуцлага:

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтээр өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэж итгэж байгаач АОУС-ын дагуу хийж гүйцэтгэж байгаа аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш.

Бусад:

Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн

ЗАХИРАЛ



М.СЭВЖИДМАА

Хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4-р хороо Цэцээ гүн 207 тоот
Утас: 976-70001981, 99096584
И-мэйл: csi_sevjee@yahoo.com

**2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ**

Гермес центр ХК
(Байгууллагын нэр)

СТА/2023/06

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
А.ХӨРӨНГӨ		
1. Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,604,423,570.75	2,979,002,199.98
Дансны авлага	-	-
Татвар, НДШ-ийн авлага	-	-
Бусад авлага	73,107,157.50	73,107,157.50
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	6,187,363.73	7,444,670.09
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,683,718,091.98	3,059,554,027.57
2. Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	3,770,561,008.83	3,607,314,984.26
Биет бус хөрөнгө	2,288,496,000.00	2,288,496,000.00
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
Дуусаагүй барилга	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,059,057,008.83	5,895,810,984.26
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,742,775,100.81	8,955,365,011.83
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
3. Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	-	-
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	71,848,608.90	99,226,981.74
НДШ-ийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	-	-
Хүүний өглөг	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	8,246,285.59	8,913,662.15
Нөөц /өр төлбөр/	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	205,226,414.92	252,511,599.96
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	285,321,309.41	360,652,243.85
4. Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	285,321,309.41	360,652,243.85
5. Эзэмшигчийн өмч		

СИ ЭС АЙ АУДИТ ХХК
Хуудасны дугаар

Өмч:	- төрийн		
	- хувийн	7,854,300,100.00	7,854,300,100.00
	- хувьцаат	-	-
Халаасны хувьцаа		-	-
Нэмж төлөгдсөн капитал		-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		-	-
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг		603,153,691.40	740,412,667.98
Эздийн өмчийн дүн		8,457,453,791.40	8,594,712,767.98
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		8,742,775,100.81	8,955,365,011.83

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Цэвэр борлуулалт	2,059,006,005.72	2,556,454,374.24
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	2,059,006,005.72	2,556,454,374.24
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	240,483,687.71	296,004,840.53
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	236,000.00	270,000.00
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	916,331,917.70	965,706,057.08
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	144,161.24	(806.72)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз(гарз) (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,383,537,936.97	1,887,022,350.97
Орлогын албан татварын зардал	138,339,377.57	188,702,315.77
(алдагдал)	1,245,198,559.40	1,698,320,035.20
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,245,198,559.40	1,698,320,035.20
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	1,245,198,559.40	1,698,320,035.20
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмч	7,854,300,100.00	7,854,300,100.00
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Гадаад валют хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг /- алдагдал/	603,153,691.39	740,412,667.98
Нийт дүн	8,457,453,791.39	8,594,712,767.98

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн (+)	2,315,409,179.08	2,853,387,637.98
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,233,687,399.06	2,775,548,354.23
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-

СИ ЭС АЙ АУДИТ ХХК
Хуудасны дугаар

Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	81,721,780.02	77,839,283.75
Мөнгөн зарлагын дүн (-)	1,194,621,648.38	1,333,348,928.60
Ажиллагчдад төлсөн	288,035,490.00	348,498,021.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	76,740,962.00	92,655,306.00
Бараа материал худалдан авахад төлсөн	44,089,999.45	31,569,135.00
Ашиглалтын зардалд төлсөн	148,015,095.24	166,173,222.59
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг	305,800.00	1,297,000.00
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	469,558,641.21	576,174,703.33
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	167,875,660.48	116,981,540.68
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,120,787,530.70	1,520,038,709.38
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	240,483,687.71	296,004,840.53
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	240,483,687.71	296,004,840.53
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	4,030,900.00	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,030,900.00	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	236,452,787.71	296,004,840.53
3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	250,161.24	26,193.29
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Төрөл бүрийн хандив	-	-
Бусад	250,161.24	26,193.29
Мөнгөн зарлагын дүн (-)	1,063,073,044.68	1,441,491,113.96
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	1,063,073,044.68	1,441,491,113.96
Бусад	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,062,822,883.44)	(1,441,464,920.67)
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	294,417,434.97	374,578,629.24
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	2,310,006,135.77	2,604,423,570.74
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	2,604,423,570.74	2,979,002,199.98

АУДИТОР  Д.ЧУЛУУНБАТ



СИ ЭС АЙ АУДИТ ХХК
Хуудасны дугаар